



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/1248

Улаанбаатар хот

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд Цэргийн бүртгэлийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 02 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Цэргийн бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
Орлогч дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;
Гишүүд:	-Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга; -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэлтэй харилцах хэлтсийн дарга; -Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга;
Нарийн бичгийн дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер;

3. Ажлын хэсэг болон дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

3.1. Дүүрэг, хороодод цэргийн бүртгэлийн ажлыг хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, гишүүдийн ажил, үүргийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гарган ажиллуулах;

3.2. Цэргийн бүртгэлийг засаг захиргааны анхан шатны нэгж хороон дээр төвлөрүүлэн зохион байгуулж, албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомж, цэргийн бүртгэлийг зохион байгуулах журмын хүрээнд сургалт, семинар явуулж, шаардлагатай гарын авлага, материалаар ханган, хяналт тавьж ажиллах;

3.3.Цэргийн бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан Цэргийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах;

3.4.Цэргийн бүртгэлээс зайлсхийгчид, завсардагчдыг эрэн сурвалжилж, бүртгэлд хамруулах ажилд цагдаагийн байгууллага, Улсын бүртгэлийн ажилтнууд болон холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулж, Цэргийн бүртгэлийн журам зөрчигчдөд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллах;

3.5.Цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийг явуулсан тухай мэдээ, тайланг 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Нийслэлийн цэргийн бүртгэлийн ажлын хэсэгт ирүүлэх;

4.Цэргийн бүртгэлийн явц, үр дүнд байнга хяналт тавьж, 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор мэдээ тайланг нэгтгэн танилцуулж, Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб хурандаа /Ж.Болдбаатар/-т үүрэг болгосугай;

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга /Э.Содномжамц/-т даалгасугай;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



САМАРСАЙХАН